

НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
№ НАУ-ГТТА 2022-26 (КНА-1031)

2022.05.12

Улаанбаатар хот

Энэ Гэрээг нэг талаас **2699877** регистрийн дугаартай "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Г.Балжинням, нөгөө талаас **5204143** регистрийн дугаартай "Клинтек" ХХК /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Ханс-Кристоф Брумберг, /хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2017 оны "Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам"-ыг үндэслэн Талууд дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Гүйцэтгэгч нь "Клинтек" ХХК-ийн барьж байгуулах Ханбогд СЦС-ын холбогдох Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээний өргөтгөлийн судалгааг хийж гүйцэтгэх /цаашид "Гэрээт Ажил" гэх/, Захиалагч нь Гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ Гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ Гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэ Гэрээний **Хавсралт-1-д** "Клинтек" ХХК-ийн барьж байгуулах Ханбогд СЦС-ын холбогдох Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээний өргөтгөлийн судалгааны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үнэ тариф"-ыг хавсаргав. Хавсралт-1 нь Гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Энэ Гэрээгээр гүйцэтгэсэн Гэрээт Ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авах буюу зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйгээр Гэрээт Ажлыг төслийн санхүүжүүлэгч санхүүгийн байгууллагуудтай хуваалцаж болно. Захиалагч нь Гүйцэтгэгчээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр төслийг санхүүжүүлэх санхүүгийн байгууллагуудтай тайлангаа хуваалцах эрхтэй байна.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 2.1 Гүйцэтгэгч нь Гэрээт Ажлын урьдчилгаа төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн ажлын 63 /жаран гурав/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Захиалагчаас хамаарсан болон тус гэрээний 8-д заасны дагуу Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд Гэрээт Ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Гэрээт Ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан дүнгээр **82,500,000.00 (наян хоёр сая таван зуун мянга)** төгрөг байна.
- 3.2 Энэ Гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс Гэрээт Ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид тус Гэрээний 3.5-д заасан нөхцлийн дагуу нэхэмжлэхийг үндэслэн, Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.4 Гүйцэтгэгч нь Захиалагч Гэрээт Ажлын төлбөрийг бүрэн төлсний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.
- 3.5 Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор нийт төлбөрийн 50 хувь болох урьдчилгаа **41,250,000 (дөчин нэгэн мянга хоёр зуун тавин мянга)** төгрөгийг нэхэмжлэлд үндэслэн Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Тус Гэрээний 7.1 тусгасны дагуу Гүйцэтгэгч нь Захиалагчид Гэрээт Ажлыг албан бичгээр мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор нийт төлбөрийн үлдэгдэл 50 хувь болох **41,250,000 (дөчин нэгэн мянга**

хоёр зуун тавин мянга) төгрөгийг нэхэмжлэлд үндэслэн Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг Гэрээт Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 102 МВт Ханбогд салхин цахилгаан станцын ТЭЗҮ (салхин станцын тооцоолсон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээг өдрөөр, цагаар, хоногоор), Нэгдсэн сүлжээтэй холболтын судалгааны тайлан (нэгдсэн сүлжээнд холбогдох цэг, ачааллын судалгаа) т зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоох шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, Гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ. Гүйцэтгэгч Гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гүйцэтгэх шаардлагатай гэж үзвэл энэ талаар Захиалагчид бичгээр мэдэгдэж, Захиалагчаас мөн бичгээр зөвшөөрөл авна.
- 4.3 Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж, ажлыг дахин хийх шаардлага гарвал холбогдох зардал, ажлын хөлсийг Гүйцэтгэгчид нэмж төлнө.
- 4.4 Захиалагч нь зураг төслийн болон бусад холбогдох норм дүрэм, стандартыг Гүйцэтгэгч зөрчсөн болон чанарын гологдол гаргасан тохиолдолд уг доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч нь Гүйцэтгэгчээс Гэрээт Ажлын гүйцэтгэлийг албан тоот болон Гэрээ дүгнэсэн актаар хүлээн авна.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь Захиалагчаас тус Гэрээний 4.1-д дурдсан шаардагдах өгөгдөл, мэдээллийг болон Захиалагчийн төлбөр төлсөн баримт зэргийг бүрэн хүлээн авсанаар Гэрээт Ажлыг эхэлнэ.
- 5.2 Гэрээт Ажлыг англи хэл дээр холбогдох норм, дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж Гэрээнд заасан хугацаанд багтаан Захиалагчид Гэрээт Ажлын гүйцэтгэлийг актаар хүлээлгэн өгнө.
- 5.3 Гэрээт Ажлын явцад алдаа гарсан нь илэрч зураг төслийн ажлын явцад хүндрэл үүсгэвэл Гүйцэтгэгч өөрийн хүч хөрөнгөөр илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах үүрэг хүлээнэ.
- 5.4 Гэрээт Ажлын гүйцэтгэл, үр дүн нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэгдсэн, техникийн нөхцөл, зургийн даалгаврыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн дахин тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөөр мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж, Гэрээт Ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.
- 5.5 Захиалагчаас шилжүүлэн өгсөн аливаа баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.6 Гүйцэтгэгч нь Гэрээт Ажлыг гүйцэтгэхэд Захиалагчаас авсан техникийн үзүүлэлт, тооцоо, баримт материал зэргийг Гэрээт Ажил дууссаны дараа Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 5.7 Цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл авах эсвэл сунгуулах зорилгоор горимын тооцоо хийж байгаа бол захиалагчид албан бичиг хүргүүлж, техникийн нөхцөл олгох хурлын төлөвлөгөөнд тусгах боломжоор хангаж ажиллана.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Захиалагч төлбөрийг Гэрээнд заасан журмаар төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алданги төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь Гэрээт Ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд Гэрээний нийт үнийн дүнгийн 0,3 %-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 6.3 Талуудын Гэрээгээр хүлээсэн үүргээс үүсэх алданги төлөх дээд хэмжээ нь Гэрээний нийт үнийн 20 %-аас хэтрэхгүй байна.
- 6.4 Гүйцэтгэгч нь Гэрээт Ажлыг алдаатай гүйцэтгэсний улмаас Захиалагчид хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгч нь үл маргах журмаар нөхөн төлнө.

- 6.5 Захиалагчийн буруугаас Гэрээт Ажлын гүйцэтгэл үр дүнгүй болж дахин горимын тооцоо хийх болсон тохиолдолд Захиалагч үл маргах журмаар Гүйцэтгэгчид дахин төлбөр төлнө.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

- 7.1. Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөр хийгдсэнээс 49 хоногийн дотор Гэрээт Ажлын анхны хувилбарыг (англи хэл дээр) Захиалагчид хүлээлгэж өгнө. Захиалагч анхны хувилбартай уншиж танилцсаны үндсэн дээр өөрийн санал, шаардлагатай өөрчлөлтүүд болон тодруулгыг Гүйцэтгэгчид 7 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ. Гүйцэтгэгч Захиалагчийн хүсэлтийн дагуу Гэрээт Ажлыг засаж залруулан эцсийн хувилбарыг (англи хэл дээр) хүсэлт хүргүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Захиалагчид хүлээлгэж өгнө.
- 7.2. Гүйцэтгэгч нь Захиалагчид Гэрээт Ажлын эцсийн хувилбарыг энэ Гэрээнд заагдсан хугацаанд албан бичгээр мэдэгдэж Захиалагч Гэрээт Ажлыг албан ёсоор хүлээж авснаар Гэрээт Ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.
- 7.3. Талууд Гэрээт Ажлыг Гэрээний гүйцэтгэлийг хүлээлцэх актаар баталгаажуулна.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Энэхүү Гэрээнд Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал гэдэгт Гэрээний аль нэг Талын энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн биелүүлэх боломжгүй байдалд шууд хүргэсэн нөхцөл байдал буюу үйл явдлыг ойлгох бөгөөд энэхүү нөхцөл байдал, үйл явдал нь Хохирогч талын урьдчилан тооцоолох боломжгүй, эсхүл урьдчилан тооцоолох боломжтой байсан ч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хохирлыг зайлуулах буюу давж гарах боломжгүй байсан бөгөөд энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас шууд үүсээгүй үр дагаварыг ойлгоно.
- 8.2. Давагдашгүй хүчин зүйл гэдэгт дараах (буюу зөвхөн үүгээр хязгаарагдахгүйгээр) үйл явдал, нөхцөл байдал хамаарна. Үүнд:
- a. тахал, халдварт өвчин, хорио цээр, дайн бүхий нөхцөл байдал бий болох, (зарлагдсан эсхүл зарлагдаагүйгээс үл хамааран) түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гадны халдлага; бүслэлт, худалдааны хориг (түлш эсхүл бусад материалыг бүрэн эсхүл хэсэгчилсэн хязгаарлалтыг оролцуулан), хувьсгал, бослого, хуйвалдаан, үймээн, терроризм; улс төрийн зорилго бүхий хорлон сүйтгэх болон барьцаалах ажиллагаа;
 - b. тэсрэлт, дэлбэрэлт буюу гал түймэр, үер, газар хөдлөлт, хөрсний гулсалт, аянга, хүчтэй шуурга, ган гачиг, цочир хүйтрэлт гэх мэт байгалийн гамшиг, эсхүл цаг агаарын бусад гэнэтийн ноцтой үзэгдэл, нөхцөл байдал;
 - c. Гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд саад болсон буюу түүнийг тасалдуулсан навигац, нисэх онгоц, усан онгоц, галт тэрэгний осол эсхүл бусад осол, сүйрэл;
 - d. машин, тоног төхөөрөмж, үйлдвэр болон бусад аливаа байгууламжийн сүйрэл эсвэл тээвэрлэлт, харилцаа холбоо, эрчим хүчний урт хугацааны тасалдал;
 - e. дээр дурдсан Давагдашгүй хүчин зүйлийн тохиолдлуудтай ижил төстэй аливаа үйл явдал, нөхцөл байдлууд.
- 8.3. Давагдашгүй хүчин зүйл бүхий нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хохирогч тал Гэрээний 8.4-д заасаны дагуу мэдэгдэл хүргүүлснээр энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх эрхтэй болно.
- 8.4. Давагдашгүй хүчин зүйл бүхий нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гэрээний аль нэг Тал нөгөө Талдаа энэ тухай бичгээр, факсаар, и-мэйлээр, утсаар болон өөр бусад хэлбэрийг сонгон нэн даруй мэдэгдэл хүргүүлснээс бусад тохиолдолд Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас үүссэн хариуцлагаас чөлөөлөгдөх эрхгүй байна.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Энэхүү Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал гаргасан Тал нь албан бичгээр нөгөө талдаа саналаа хүргүүлнэ. Хүлээн авсан Тал нь ажлын 5 хоногт хариуг албан бичгээр хүргэнэ.

- 9.2 Нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан зөвшөөрсөн тохиолдолд тус өөрчлөлтийг Гэрээнд бичгээр үйлдэж оруулах бөгөөд Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.3 Энэ Гэрээний нөхцлүүдийг зөрчсөн буюу Гэрээт Ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 9.4 Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцөлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 9.5 Энэ Гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Талууд тус бүр нэг эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 9.6 Гэрээт Ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсанаар Гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК:

Гүйцэтгэх захирал

.....Г.Балжинням

Тэргүүн дэд захирал бөгөөд

Ерөнхий диспетчер

.....Б.Баатар

Зах зээл, санхүү хариуцсан дэд захирал

.....Ц.Өнөрмаа

СЭЗА-ны дарга

.....Т.Бямбажав

ГТТА-ны дарга

.....Х.Болд-Эрдэнэ

ЗЗЗА-ны дарга

.....Г.Мөнхбат

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

.....Ч.Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн

.....Д.Алимаа

Захиалагчийг төлөөлж:

"Клинтек" ХХК

Гүйцэтгэх захирал

.....Ханс-Кристоф Брумберг



Гүйцэтгэгчийн хаяг:

17032. Улаанбаатар хот
Хан-уул дүүрэг, Чингисийн
Өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр
Утас: 70041371
Факс: 70043467
И-мэйл:ndc@ndc.energy.mn

Захиалагчийн хаяг:

14230 Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
13-р хороолол
Олимпийн гудамж-39
Жи центр, 51 тоот
Утас: 70110546



Нэмэлт ажил үйлчилгээний 2022 оны 05 сарын 12-ны өдрийн
"НАУ-ГТТА 2022-05 тоот гэрээний хавсралт-1
(КНА - 1031)


Ханбогд салхин цахилгаан станц-Сүлжээний өргөтгөлийн судалгааны гүйцэтгэх ажлын задаргаа

2022-05-12

№	Үндсэн агуулга	Гүйцэтгэх ажил, тооцоо, судалгаа	Үнийн дүн, сая төгрөг
1	Монголын цахилгаан сүлжээний өнөөгийн байдал	1. Ачааллын байдал (хэрэглэгч ба генератор/цахилгаан станц) 2. Цахилгаан эрчим хүчний хангамж (цахилгаан эрчим хүчний хангамж/дамжуулалтын хүндрэл гацалт) 3. Сүүлийн 5 жилд хийсэн чадлын хязгаарлалт	75,000,000
2	Монголын цахилгаан шугам сүлжээг өргөтгөх/бэхжүүлэх төлөвлөгөө	4. Цахилгаан дамжуулах ЦДАШ-ын төслүүд 5. Сэргээгдэх эрчим хүчний төслүүд (СЦС, УЦС, НЦС гэх мэт) 6. Цахилгаан хуримтлуулах батарей 7. Одоо байгаа сүлжээний төслүүдийн хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх 8. Шинэ цахилгаан станцын төслүүд	
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээг хөгжүүлэх	9. Ойрын 5 жилд нэгдсэн сүлжээнд холбогдох төлөвлөгөөт хэрэглэгчид, хүчин чадал, ачааллын муруй, нийт хэрэглээний урьдчилсан тооцоо	
4	Дүгнэлт	10. Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн сүлжээнд үзүүлэх нөлөө 11. Салхин цахилгаан станцын чадлыг хязгаарлах нөхцөл байдалд үзүүлэх нөлөө	
	Үнэлгээ		75,000,000
	НӨАТ		7,500,000
	Нийт үнэлгээ		82,500,000

Хянасан:


Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер

 Б. Баатар

Горим тооцоо, төлөвлөлтийн албаны дарга

 Х. Болд-Эрдэнэ

Горим тооцооны хэсгийн ахлах инженер

 Ц. Сэргэлэн

Гүйцэтгэсэн:

Горим тооцооны инженер

 С. Сайнболд

НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "НАУ-ГТТА 2022-26"(КНА-1031) ТООТ ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН АКТ

2022 оны 09-р сарын 19

Улаанбаатар хот

"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК /цаашид Гүйцэтгэгч" гэх/, "Клинтек" ХХК /цаашид "Захиалагч" гэх/ нарын хооронд байгуулсан КНА-1031 гэрээний дагуу "Клинтек" ХХК-ийн Ханбогд СЦС-ыг барьж байгуулах ажлын хүрээнд сүлжээний өргөтгөлийн тооцоог хийж дууссан тул Талууд энэ гэрээ дүгнэсэн актыг үйлдэн гэрээт ажлыг хүлээлцэв.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд багтаан гэрээт ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн байна. Үүнд:

- Монголын цахилгаан сүлжээний өнөөгийн байдлын судалгаа хийсэн
 - Ачааллын байдал
 - Цахилгаан эрчим хүчний хангамж
 - Сүүлийн 5 жилийн чадлын хязгаарлалт
- Монголын цахилгаан шугам сүлжэээ өргөтгөх, бэхжүүлэх төлөвлөгөө
 - Цахилгаан дамжуулах ЦДААШюын төслүүд
 - Сэргээгдэх эрчим хүчний төслүүд
 - Цахилгаан хуримтлуулах батарей
 - Одоо байгаа сүлжээний төслүүдийн хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх
 - Шинэ цахилгаан станцын төслүүд
- Цахилгаан эрчим хүчний хэрэглээг хөгжүүлэх
 - Ойрын 5 жилд нэгдсэн сүлжээнд холбогдох төлөвлөгөөт хэрэгэлэгчид, хүчин чадал, ачааллын муруй, нийт хэрэглээний урьдчилсан тооцоо
- Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн сүлжээнд үзүүлэх нөлөө
- Салхин станцын чадлыг хязгаарлах нөхцөл байдалд үзүүлэх нөлөө

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1. Гэрээт ажлын төлбөр **82,500,000.00 (наян хоёр сая таван зуун мянга)** төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн, Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.2. Гүйцэтгэгч нь Захиалагч гэрээт ажлын төлбөрийг бүрэн төлсөний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.
- 2.3. Гэрээт ажлын төлбөрийг Захиалагч 2022 оны 5-р сарын 20-нд болон 2022 оны 9-р сарын 13-нд хоёр хувааж 100% бүрэн төлсөн.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ

- 3.1. Гүйцэтгэгч гэрээний гүйцэтгэлийг 2022 оны 8-р сарын 1-нд хүлээлгэн өгөв.
- 3.2. Захиалагч гэрээт ажлын төлбөрийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн дагуу 100% төлж барагдуулсан байна.
- 3.3. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээт ажлын гүйцэтгэлийг 100 хувь биелүүлсэн тул гэрээг энэ актаар баталгаажуулав.
- 3.4. Энэ гэрээт ажлын гүйцэтгэлийг гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулахдаа 2022 оны 06-р сарын 10-ны өдрийн №НХГ01/2022 дугаарын "Нууц мэдээлэл задруулах хориглох тухай гэрээ"-нд заасан нөхцлийг мөрдөнө. .

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК:

Гүйцэтгэх захирал

Г.Балжинням

Ерөнхий диспетчерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Баатар

СЭЗА-ны дарга

Т.Бямбажав

ЗЗЗА-ны дарга

Ц.Өнөрмаа

ГТТА-ны дарга

Х.Болд-Эрдэнэ

ЗЗЗА-ны ахлах мэргэжилтэн

Ч.Энхжаргал

Гэрээний мэргэжилтэн

Д.Алимаа

Захиалагчийг төлөөлж:

"Клинтек" ХХК

Гүйцэтгэх захирал

Ханс Кристоф Брумберг